

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ
/2023 оны жилийн эцсийн байдлаар/

№	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2020	2023 он			Хэрэг жилт	
			Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Өөрчлөлт		
1.	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн нийт өрхөд эзлэх хувь	33,3	34	34	-	Тайлбар 2021 онд Инженерийн бүрэн хангамжтай орон сууц гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 4909, 10000 айлыг инженерийн дэд бүтцэд холбох ажлын хүрээнд 4256 орон сууц, ашиглалтын шаардлага хангахгүй барилга 2266, НОСК – 221 орон сууц, зах зээлийн 47116 орон сууц баригдсан. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийслэлд 14184 айлын орон сууц, орон нутагт 3294 айлын орон сууц нийт 17478 орон сууц шинээр ашиглалтад орсон. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 2021-2023 онд нийт 7692 айлын орон сууц ашиглалтад орж, төрийн болон орон нутгийн түрээсийн 6170 айлын орон сууцны сан бүрдүүлж, нийслэл болон орон нутагт 2021 онд 17478, 2022 онд 23201, 2023 онд 19196, нийт 59875 айлын орон сууц шинээр ашиглалтад орсон байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийслэлд 14578 айлын орон сууц, орон нутагт 4618 айлын орон сууц нийт 19196 орон сууц шинээр ашиглалтад орсон.	100
2.	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	82,5	83	83,5	0,5%	Тайлбар АНУ-ын МСС-ийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр барих төслийн хүрээнд Биокомбинатад 12 цооног, Шувуун фабрикт 16 цооногийн өрөмдлөгийн ажил дууссан, өрөмдлөгийн ажил 93,3%-тай, ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажил 52,91 %-тай байна. Ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, шинээр барих ажлын хүрээнд нийт 36,41 км цэвэр усны шугам, усан сан 2х1000м3, насосны станц-2 ком шинээр барьж, ашиглалтад оруулсан. Мөн Дорноговь, Дархан-Уул, Орхон, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь аймгийн төвийн гэр хорооллын ус түгээх байруудад 100% ухаалаг төхөөрөмж суурилуулж, иргэдэд цагийн хязгааргүй үйлчилгээ үзүүлж байна.	100
3.	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан хүн амын эзлэх хувь	38	40	69,2	29,2	Тайлбар Гэр хорооллын айл, өрхийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэх ажлын хүрээнд: 1. Архангай аймагт 10; 2. Баянхонгор аймагт 196; 3. Сүхбаатар аймагт 7; 4. Дорнод аймагт 3; 5. Өмнөговь аймагт 180; 6. Орхон аймагт 566; 7. Ховд аймагт 42; 8. Өвөрхангай аймагт 2 Нийслэлд 3430 ширхэг эко жорлон суурилагдсан. Нийт 4436 айлын нүхэн жорлон шинэчлэгдсэн.	100

4.	Ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо, өссөн дүнгээр	6476	30476	35707	1337	2021 онд 13,292 иргэн, 2022 онд 7,847 иргэн, 2023.12.22-ны өдрийн байдлаар 8,092 иргэн, нийт 29,231 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд нэмж хамруулсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хоёрдугаар хавсралтаар баталсан ипотекийн зээлд хамрагдсан 6,476 иргэдийн суурь тоог 28,804 иргэнээр нэмэгдүүлж 2023.12.22-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 35,707 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан байна.	100
5.	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд шинээр баригдаж, ашиглалтад орсон орон сууц, айлын тоо өссөн дүнгээр	5,189	11856	12881	1025	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 2021 онд 695 айлын, 2022 онд 5,684 айлын, 2023 оны 12 дугаар сарын байдлаар 1,313 иргэн, нийт 7,692 айлын орон сууцыг төслийн хүрээнд ашиглалтад оруулж 2020 суурь 5189 айлын орон сууцыг 7,692 айлын орон сууцаар нэмэгдүүлж 2023 оны 12 дугаар сарын өссөн дүнгээр 12,881 айлын орон сууцыг ашиглалтад оруулаад байна.	100
6.	Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийн хүрээнд инженерийн хангамжид холбогдсон өрх, тоо өссөн дүнгээр	300	3000	9618	167	Гэр хорооллын өрхийг инженерийн хангамжид холбож, орон сууцны нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд аймгуудын хэмжээнд 2021 онд 3294, 2022 онд 3718, 2023 оны 12 дугаар сарын байдлаар 2,606, нийт 9618 өрх айлын орон сууц ашиглалтад орж, инженерийн хангамжид холбогдсон байна.	100
7.	Шинэ суурьшил, дагуул, хаяа хот, тосгодыг хөгжүүлэх хүрээнд шинээр ашиглалтад орох орон сууц, айлын тоо өссөн дүнгээр	4,222	8,000	-	-	<p>“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний төсөл боловсруулагдсан. Тус төлөвлөгөөнд Улаанбаатар хот нь 10 гаруй дагуул, хаяа хот тосгодтой байхаар тусгагдсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Жаргалант-Рашаант-361 орчмын бүс 2040 он гэхэд 30 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 2 900 өрхтэй байхаар; 2. Туул-Сонгино-Өлзийт суурьшлын бүс 2040 он гэхэд 40 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 8 300 өрхтэй байхаар; 3. Багануур 2040 он гэхэд 85 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 21700 өрхтэй байхаар; 4. Налайх 2040 он гэхэд 75 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 21500 өрхтэй байхаар; 5. Гачуурт тосгон 2040 он гэхэд 10 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 1200 өрхтэй байхаар; 6. Зуслангийн бүс 2040 он гэхэд 30 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 9580 өрхтэй байхаар; 7. Эмээлт 2040 он гэхэд 40 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 7 600 өрхтэй байхаар; 8. Шинэ Зуунмод 2040 он гэхэд 34 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 25 858 өрхтэй байхаар; 9. Багахангай 2040 он гэхэд 16 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 4 600 өрхтэй байхаар; 10. Хонхор 2040 он гэхэд 35 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 10 000 өрхтэй байхаар; 11. Тэрэлж орчмын бүс 2040 он гэхэд 5 000 хүн амтай болж, инженерийн хангамжид холбогдсон 600 өрхтэй байхаар; 	50

					<p>НЗД бөгөөд УБХЗ-аар Х.Нямбаатар томилогдсонтой холбогдуулан БХБ-ын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатар нарын 2023.11.09-ний өдөр зохион байгуулагдсан албан уулзалтаар Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийн төслийг гадаадын мэргэжлийн экспертүүдээр хянуулж, санал зөвлөмж авахаар шийдвэрлэж, нийслэлийн хэмжээнд барилга, хот байгуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусган батлуулахаар 2023.11.21-ний өдрийн 1/4206 тоот албан бичгээр Х.Нямбаатар даргад хүргүүлсэн.</p> <p>Төлөвлөгөөний төсөлд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэх гадаадын мэргэжлийн экспертүүдийг сонгон авч ажиллуулах, шаардагдах санхүүжилтийг нийслэлийн төсвийн тодотголд тусгуулах ажлыг 2024 оны 1-р улиралд багтаан шийдвэрлэж УИХ-д өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулахаар тусгагдсан.</p>	
8.	Барилгын материал, ус, эрчим хүчний хэрэглээний гэрчилгээ, шошго авсан орон сууцны барилга, тоо өссөн дүнгээр	-	-	1	<p>2 ААН Ногоон гэрчилгээ авсан.</p> <p>Кингспан ХХК-ийн эрчим хүчний хэмнэлттэй ногоон бүтээгдэхүүндээ “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг” авах хүсэлтийг дэмжин БОАЖ-ийн сайдад 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 01/3407 тоотой уламжилснаар тус компанид 2021 онд “Ногоон гэрчилгээ” олгосон.</p> <ol style="list-style-type: none"> Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Барилгын салбар дахь стратегийн түншлэл” төсөлд эрчим хүчний тооцоолуурын программын тухай 2023.01.25-ны өдрийн 9/279 тоотой мэдээлэл хүргүүлэв. Барилга, хот байгуулалтын сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан А/257, А/252 дугаар тушаалаар баталсан “Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам”-ын хэрэгжилтийг 2022, 2023 оны байдлаар гарган ирүүлэхийг хүсч “БХТ” ТӨААТҮГ-т 2023.03.14-ний өдрийн 3/844 тоот албан бичиг хүргүүлэн мэдээлэл авч, холбогдох танилцуулгад хавсаргав. <p>2022 оны 10 дугаар сараас хойш Халаалт, агаар сэлгэлтийн 84 эксперт, инженерүүдэд 2 удаа сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээг барилгын ажлын зураг төсөлд олгож, бүртгэлжүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - 2022 онд 315 зураг төсөл - 2023 онд 585 зураг төсөл <ol style="list-style-type: none"> Европын Холбооны Свич-Эшиа II хөтөлбөрийн санхүүжилттэй “Дулаан шийдэл II” төслийн хөндлөнгийн зөвлөх хорооны хуралд 2023.04.28-ны 10:00 – 12:00 цагт оролцож, тус төсөлтэй хамтран Эко шошго олгох талаар хамтран ажиллах хүсэлт тавьсан. НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр (ҮТХН)-ийн хэрэгжилтийг дэмжих” төслөөс “Барилгын материалын зардал-өгөөжийн шинжилгээ” сэдэвт судалгааны ажил хийж байгааг дэмжин барилгын материалын үйлдвэрүүдээс судалгаа авах хүсэлтийг 8 компанид 2023.04.28-ны өдрийн 6/1548 тоотой хүргүүлсэн. “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ын 5.1, 5.2-т заасан комисс болон техникийн зөвлөлд салбарын яамны төлөөллийг оролцуулахаар тус 	100

					<p>зөвлөл, комисст ажиллах хүний нэрийг БОАЖЯ-нд 2023.04.11-ний өдрийн 1/1239 тоотой хүргүүлсэн.</p> <p>6. “Барилгачдын нэгдсэн холбоо” ТББ-аас зохион байгуулдаг “Барилгын материал үйлдвэрлэлийн технологич инженерийн мэргэшсэн, зөвлөх горилох” сургалтад “Барилгын салбарын ногоон хөгжлийн бодлого” сэдвээр 2 багц цагийн хичээлийг 2 удаа заасан.</p> <p>7. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийн талаар мэдээлэл, төслийн драфт боловсруулан USAID-ын “Эрчим хүчний засаглал” хөтөлбөрийн багт хамтран ажиллах саналыг 2023.11.16-ны 6/4162 тоот албан бичгээр болон и-майлаар хүргүүлсэн.</p> <p>8. Барилгын тухай хуулийн хэлэлцүүлгийг 2023.11.15-нд зохион байгуулж, барилгын материалд тавигдах “ногоон”, “тогтвортой”, “нөөцийн хэмнэлттэй” гм шаардлага, нэр томъёог тодорхой болгох, хуульчлах талаар санал өгсөн.</p> <p>9. GERES ОУБ-ын “Дулааны шийдэл-2” төслийн хөндлөнгийн зөвлөх хорооны хуралд 2023.11.22-ны өдөр 10.00-12.00 цагт оролцож, төслийг аймгуудад өргөтгөн хэрэгжүүлэх талаар санал солилцов.</p> <p>Тус байгууллагын Төв Азийн бүсийн захирал Квентин Морроу болон “Дулааны шийдэл-2” төслийн зохицуулагч Эллиан Жерри нартай 2023.11.27-ны өдөр 14.00-15.00 цагт уулзаж, барилгын материалын үйлдвэрийн салбарт хамтран ажиллах боломжийн талаар санал солилцсон.</p> <p>10. “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ын дагуу 2 ААН Ногоон гэрчилгээ авсан</p> <p><i>“Голден бизнес групп” ХХК-ийн импортлохоор зорьж буй CLT+GLTWI /cross-laminated timber/ технологийг судлан Ногоон гэрчилгээ, Эко тэмдэг олгох хүсэлтийг БОАЖЯ-нд 2022.06.21-ний өдрийн 3/3001 тоотой хүргүүлсэн.</i></p>		
9.	Дулаалах төсөлд хамрагдсан нийтийн зориулалттай угсармал орон сууцны барилга, айлын тоо	5/300	27/2100	50	-	<p>2021 онд нийслэл болон орон нутагт улсын төсөв, орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар 50 орчим нийтийн зориулалттай угсармал орон сууцны барилгыг дулаалсан.</p> <p>Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022.04.29-нд батлагдаж, тус хуулийн 13.4. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно” гээд 13.4.6-д “нийтийн эзэмшлийн байр, орон сууцны засвар, шинэчлэл” гэж туссан тул төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр дулаалга, засварын ажил 2022 оны сүүлийн хагас, 2023 онд хийгдээгүй. Олон улсын “Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” (НАМА/MAF) /Mitigation Action Facility/ хэрэгслийн санхүүжилтээр хэрэгжих “УБ хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх нь” төслийн удирдах хороог БХБ-ын дэд сайдын ахалснаар байгуулан ажиллаж байна. Төслийн нэгж буюу GIZ (ГОУХАН)-ийн зүгээс угсармал барилгуудыг дулаалах тооцоо, судалгааг хийж, дулаалах эхний барилгыг сонгосон. Тус барилгыг 2024 оны хавар дулаалахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	70

10	Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж барилгажуулах төслийн хүрээнд шинээр ашиглалтад орсон орон сууц, айлын тоо	301	1500	1305	1566	Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж барилгажуулах төслийн хүрээнд 2021 онд 387, 2022 онд 611, 2023 оны 12 дугаар сарын байдлаар 307, нийт 1305 айлын орон сууц ашиглалтад орсон.	90
11	Шинээр байгуулагдсан үндсэн нэр төрлийн барилгын материалын үйлдвэр, тоо	3	4	14	+10	<p>“Лэл минерал” ХХК-ийн арматурын үйлдвэр, “Дин Шин цутгамал” ХХК-ийн стандартын бус ган бүтээгдэхүүний үйлдвэр 2021 онд шинээр ашиглалтад орж, үйл ажиллагаа явуулж эхэлсэн тул БХҮНТ ТББ-ын Баталгаажуулалтын албанаас “Тохирлын гэрчилгээ” авсан. 2021 онд бетон зуурмагийн үйлдвэр-10, төмөр бетон эдлэлийн үйлдвэр -1, хуванцар цонхны үйлдвэр -1, хуурай хольцын үйлдвэр -1, хуурай бетоны үйлдвэр -1, нийт 14 үйлдвэр шинээр ашиглалтад орсон байна.</p> <p>Ховд аймагт цементийн үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулсан. БНХАУ-аас 2022 онд 45 мэргэжилтэн урьж ажиллуулсан. Эдгээр гадаадын ажиллах хүч 5-6 сард ирж, барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралтын ажилд оролцсон.</p> <p>Барилгын материалын доорх үйлдвэрүүд 2023 оноос үйл ажиллагаа нь жигдрэн ажиллаж байна. Үүнд:</p> <p><u>Элс, хайрга, бетоны дүүргэгчийн үйлдвэр:</u></p> <ul style="list-style-type: none"> - “Байгууламж Од” ХХК механик элсний үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулан, туршилт тохируулгаа хийн энэ оноос жигдрэн ажиллаж байна. - Архангай аймагт 2022 онд “Ашид бэхи” ХХК-ний дайрга бутлан ангилах үйлдвэр ашиглалтанд орж, 2023 онд үйл ажиллагаа нь тогтворжиж байна. <p><u>Цемент, шохойн үйлдвэр:</u></p> <ul style="list-style-type: none"> - Баруун бүсийн Ховд аймагт “Вестерн Холд” ХХК-ийн жилд 250 мянган тонн цемент үйлдвэрлэх үйлдвэр 2023 оны 1 дүгээр сард ашиглалтад орж, үйл ажиллагаа тогтворжсон. Үйлдвэрлэлээ 11 сар хүртэл явуулж, 11 сарын 1-нээс өвлийн улирлын зогсолт хийсэн. - Төв аймгийн Баян сумын нутаг дэвсгэрт орших “Баян цемент” ХХК нь шохой боловсруулах үйлдвэрийн өргөтлөө 2022 онд эхлүүлж, технологио шинэчилсэн. - Говь-Алтай аймагт Макс группын “Цэн газар” ХХК шохой, цементийн үйлдвэр байгуулж, 2024 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. <p><u>Гангийн үйлдвэр:</u></p> <ul style="list-style-type: none"> - Дорноговь аймгийн Алтан ширээт сумын нутаг дэвсгэрт орших Цагаан суваргын ордыг түшиглэн “Монголын Алт (МАК)” ХХК хүдрийн боловсруулалтын үйлдвэрийг байгуулан, 2025 он гэхэд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна. - Дархан уул аймагт арматурын томоохон хүч чадал бүхий “Чуань Мон арматур” ХХК-ийн 10.000 тонн ган туйван үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр 2021 онд ашиглалтанд орж, 2023 оноос үйл ажиллагаа нь жигдэрч байна. - Мяндас полимер арматурын үйлдвэр байгуулах 2 компанид мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгч, тус үйлдвэрүүд ашиглалтанд орсон. “Мяндас арматур” ХХК-ийн үйлдвэр 2022 оны 5 сард, “Монгол базалт” ХХК-ийн үйлдвэр 10 сард ашиглалтад орж, энэ онд үйл ажиллагаа нь жигдэрсэн. <p><u>Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр:</u></p>	100

					<p>- Кабелийн сувагчлалын атираатай хатуу полиэтилен хоолой үйлдвэрлэдэг “АНСЭХЭ” ХХК нь Сонгинохайрхан дүүргийн Улаанчулуутад хог хаягдал боловсруулах түүхий эдийн үйлдвэрийг 2022 оны 9 сард ашиглалтад оруулж, импортоор оруулж ирдэг PVC /Поли Винил Хлорид/-г 50 хүртэл хувиар хэмнэх боломжтой болсон.</p> <p>Цахилгаан станцын үнсний агуулахаас үнс авч боловсруулах “Лог хоум лимитед” ХХК-ийн үйлдвэр ашиглалтанд орсон.</p>	
12	Импортыг орлох, экспортыг дэмжих шинэ материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тоо	-	10	Судалгаа хийгдэж байна.	<p>Дотоод орчны агаарын чанарын 1 судалгаа,</p> <p>Үнсний 7 судалгаа,</p> <p>Хүйтэн орчинд бэхжих бетоны бат бэхийн судалгаа 1</p> <p>ОХУ-д цемент экспортлохын тулд тус улсын доорх стандартуудыг үндэсний стандарт болгон боловсруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Цементийн үйлдвэрлэлд хэрэглэх идэвхт эрдэст нэмэлт материал. Идэвхийг тодорхойлох арга” /ГОСТ 25094-2015/, - “Цемент, цемент үйлдвэрлэлийн материал. Химийн шинжилгээний арга” /ГОСТ 5382:2019/, - “Полифракцийн элс ашиглан турших арга” /ГОСТ 30744-2001/, - “Нэрмэл ус. Техникийн нөхцөл” /ГОСТ Р 58144-2018/ <p>Цементийн үйлдвэрүүдийг дэмжин ажиллав.</p> <ol style="list-style-type: none"> 1. Урин дулааны улирал болж, барилгын ажил эхэлж байгаатай холбогдуулан цементийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг тасалдуулахгүй хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, цахилгаан эрчим хүчийг тасралтгүй нийлүүлэх талаар санал боловсруулж, Эрчим хүчний сайдад 2023.04.03-ны өдрийн 1/1090 тоотой хүргүүлсэн. 2. Мөн цементийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулахад крытый болон полувагоны хүртээмжийг нэмэгдүүлж, дэмжин ажиллах тухай санал боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн сайд, Улаанбаатар төмөр зам” ХНН-т 2023.04.03-ны өдрийн 1/1116 тоотой хүсэлт хүргүүлсэн. 3. Цементийн үйлдвэрлэл, импорт, үнэ ханшийн болон хэрэглээний судалгаа, бусад холбогдох мэдээллийг 2013-2023 оны байдлаар гарган 2023.04.06-ны өдрийн 1/1190 тоотой Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. 4. "Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" стандартын хэрэгжилт нь барилгын материалын үйлдвэрүүдэд бодит бэрхшээл үүсгэж байгаа талаар асуудал боловсруулж, автотээврийн хэрэгслийн ачааны жинг нэмэгдүүлэх, хүнд техникийн замын трасс батлуулах талаар хамтарсан ажлын хэсэг байгуулж, арга хэмжээ авах хүсэлтийг Зам тээврийн хөгжлийн сайдад 2023.04.12-ны 1/1259 тоотой хүргүүлсэн. 5. “Мон цемент билдинг материалс” ХХК-ийн татварын асуудлаар Сангийн яамтай хамтарсан уулзалт зохион байгуулах тухай хүсэлтийг 2023.04.12-ны өдрийн 1/1263 тоот албан бичгээр Гаалийн ерөнхий газарт хүргүүлэв. 6. Баруун бүсийн Ховд аймагт “Вестерн Холд” ХХК-ийн жилд 250 мянган тонн цемент үйлдвэрлэх үйлдвэр 2023 оны 1 дүгээр сард ашиглалтад орсон. 	70

					<p>7. Төв аймгийн Баян сумын нутаг дэвсгэрт орших “Баян цемент” ХХК нь шохой боловсруулах үйлдвэрийн өргөтлөө 2022 онд эхлүүлж, технологио шинэчилж байна.</p> <p>8. Говь-Алтай аймагт Макс группын “Цэн газар” ХХК шохой, цементийн үйлдвэр байгуулж, 2024 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. ОХУ-д цемент экспортлох ажлын хүрээнд тус улсын Тохирлын үнэлгээний ГОСТ 56836-2022 “Правила сертификаций цементов” стандартын дагуу цемент үйлдвэрлэгч томоохон компаниуд бэлтгэл хангахаар ажиллаж байна. <i>“Кинг Спан” ХХК-ийн импортлох бүтээгдэхүүнийг Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай асуудлыг Гаалийн тарифын зөвлөлөөр хэлэлцүүлэх тухай хүсэлтийг Сангийн сайд Б.Жавхланд 2022.05.24-ний өдрийн 1/2526 тоотгоор хүргүүлсэн.</i></p>		
13	Барилга угсралтын ажлын улирлын нөлөөллийг бууруулах судалгаа, үйлдвэрлэл, тоо	-	2	1	-	<p>Барилга угсралтын ажлын улирлын нөлөөллийг бууруулах зорилгоор “Хүйтний улиралд цутгамал бетон, төмөр бетон бүтээцийн ажлыг гүйцэтгэх аргачлал” болон Өвлийн нөхцөлд цутгамал бетон төмөр бетон бүтээцийн цутгах арга, аргачлал БД боловсруулах ажил хийгдэж байна. Барилгын ажилд тавигдах технологийн шаардлагыг хангуулж улирал харгалзахгүй гүйцэтгэх боломжтой юм.</p> <p>2023 онд: Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр ШУТИС-ийн БАС-ийн доктор проф. Дүйнхэржавын боловсруулсан “Хүйтний улиралд бэхжүүлсэн бетоны нүх сүвийн бүтэц, тархалтын судалгаа” төслийн тайланг 2023 оны 12 дугаар сарын ...-ны өдөр яамны ШУТЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсан.</p>	90
14	Инженер геологийн болон инженерийн бэлтгэл ажлын судалгаа, тоо	-	2	2	-	<p>УБ хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулах гүйцэтгэгч “Престиж инженеринг” ХХК-тай 2021.05.06-нд гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн. Эхлэлийн болон дунд шатны тайлан ирүүлсэн. Гэрээгээр 2021 онд дуусах байсан боловч гэрээг сунгаад байна. “Улаанбаатар хотын гадаргуугийн ба газар доорх үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх арга аргачлал, загварчлал хийх, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө”-г НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулахаар уг баримт бичгийг боловсруулах ажлын даалгаварт заасан үе шатны дагуу хэрэгжсэн бөгөөд БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн 2023.04.21-ний өдрийн хурлаар хэлэлцэн дэмжигдсэн. НИТХ-ын 2023.06.21-ний 65 дугаар тогтоолоор батлагдсан. Сайдын зөвлөлийн 2023.06.28-ны 4-р хурлаар дэмжиж, 2023.09.06-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. УБ хот болон дагуул хаяа хот тосгодын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөтэй болсон.</p>	100
15	Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийн судалгаа, үйлдвэрлэл, тоо	-	2	2		<p>Хаягдал гялгар уутыг дахин боловсруулан нүхэн жорлонгийн доторлогооны иж бүрдэл болон худгийн таг, кольцо үйлдвэрлэж, 1000 гаруй гэр хорооллын өрхийн нүхэн жорлонгийн асуудлыг шийдвэрлэн, хөрсний бохирдлын хэмжээг бууруулахад хувь нэмэр оруулж буй үндэсний үйлдвэрлэгч Пластик центр ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. Тус компаниас бүтээгдэхүүний чанарын хяналт, баталгаажуулалт мэргэжлийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах, тус бүтээгдэхүүнд стандарт гарган батлуулах, Сурталчилгаа хийх, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх тал дээр дэмжлэг авахыг хүсэж, албан</p>	90

						<p>бичгээр хүсэлтээ уламжилсан. Асуудлыг судлан, эерэг үр дүн гаргахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаар холбогдох нэгжүүдэд танилцуулж, шаардлагатай техникийн зохицуулалтыг боловсруулах талаар зөвлөгөө өгсөн.</p> <p>Барилгын шинэ техник технологийг нэвтрүүлж, Грийн ресорт амралтын газарт суурилуулан бодит хэмнэлт, сурталчилгаа хийж буй Ультрасоник ХХК-ний үйл ажиллагаатай танилцаж, салбарын норм, нормативын тогтолцоо, хууль эрх зүйн баримт бичигт өөрчлөлт оруулах боломжийн талаар зөвлөлдөж санал солилцлоо. Монгол Улсад эрчим хүчний хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай ногоон барилгыг хөгжүүлэх, иргэдэд зөв мэдээлэл өгч, сэдэл өгөх, сэтгэлгээг өөрчлөх тал дээр дэмжлэг үзүүлэх, төвлөрсөн системээс татгалзаж, байгальд ээлтэй, цомхон бүтцийг бий болгох чиглэлээр судалгаа хийх, тус компанийн хэрэглээнд үндэслэсэн тооцоолол гаргах, хамтран ажиллаж байна.</p> <p>2023 онд:</p> <p>1. Хог хаягдлыг дахин боловсруулах судалгааны чиглэлээр: “Барилгын материалд үнс хэрэглэх технологийн судалгаа”, “Барилгын материалын хортой бодисын ялгарлын судалгаа”-г ШУТС-ийн захиалгат ажлын жагсаалтад оруулуулахаар тус сангийн Инженерийн ухаан, технологийн салбар зөвлөлд 2023.09.22-ны өдөр танилцуулсан. Тус зөвлөлөөс үнсийг барилгын материалд хэрэглэх талаар хийгдсэн судалгааны ажлууд тус санд байдаг талаар дурдсан тул тэдгээр төслүүдийн хувийг ирүүлэх тухай хүсэлтийг 2023.11.13-ны 6/4123 тоот албан бичгээр ШУТС-д хүргүүлж, судалгааны 7 төслийн тайланг файлаар авсан.</p> <p>Барилгын дотоод орчны агаарын чанарын судалгааны чиглэлээр: “Түмэн Амгалан Ордон” ХХК-иар барилгын дотоод орчны агаарын чанарын бодлого, зохицуулалтын баримт бичгийн суурь судалгаа хийлгэсэн. Мөн “Ногоон титэм” ХХК-иар барилгын дотоод орчны агаарын чанарт барилгын материалаас нөлөөлөх нөлөөллийн судалгаа хийлгэсэн. Эдгээрийг судалгааны санд нэгтгэснээр эрхзүйн баримт бичиг боловсруулах боломж бүрдээд байна.</p>	
16	Ногоон барилгын технологи нэвтрүүлэх гарааны компани, тоо	-	10	1		<p>Эрчим хүчний хэмнэлттэй ногоон бүтээгдэхүүндээ “Ногоон гэрчилгээ”, “Эко тэмдэг” авах хүсэлт ирүүлсэн Кингспан ХХК-ийг дэмжсэн. Тус компани 2021 онд “Ногоон гэрчилгээ” авч, Эрдэнэт хотод Спорт цогцолборын барилгыг барьж ашиглалтад оруулсан.</p> <p>2023 онд: “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам”-ын 5.1, 5.2-т заасан комисс болон техникийн зөвлөлд салбарын яамны төлөөллийг оролцуулахаар тус зөвлөл, комисст ажиллах хүний нэрийг БОАЖЯ-нд 2023.04.11-ний өдрийн 1/1239 тоотой хүргүүлсэн. Уг зөвлөлөөр барилгын цонхонд суурилуулдаг агаар шүүгчийн үйлдвэрлэл явуулдаг “Окфил эко” ХХК-нд “Ногоон гэрчилгээ” олгосон.</p> <p>2023 онд барилгын салбарт нэг компани энэ гэрчилгээг авсан.</p>	70
17	Барилгын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ	3.7	4.1	3	-1.4	<p>Дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 68.9 их наяд төгрөгт хүрсний 2.0 (3.0%) их наяд төгрөгийг барилгын салбар бүрдүүлж байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 2020 оны мөн үеэс 720.6 (52.6%), 2021 оны мөн үеэс 719.3 (52.5%), өмнөх оны мөн үеэс 304.3 (17.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн</p>	90

					байна. Барилгын салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 2,088.2 тэрбум төгрөг, зэрэгцүүлэх үнээр 898.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.2 (0.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.	
18	Ногоон барилгын үнэлгээний систем	-	-		<p>Тус яамнаас дэлхийн 150 гаруй улсад хэрэгжүүлж буй, Дэлхийн банк, ОУСК-аас нэвтрүүлсэн ногоон барилга, байгууламжийн стандарт үнэлгээ болох Ногоон барилгын үнэлгээний EDGE (Excellence in Design for Greater Efficiencies) системийг хэрэгжүүлэхээр 2019 онд БХБЯ, ЭХЗХ, БОАЖЯ, ОУ-ын Санхүүгийн корпорацитай Санамж бичиг байгуулж, ОУ-ын эрхтэй 2 экспертийг бэлтгэсэн. Энэ үнэлгээний систем нь барилгыг эрчим хүч, усны хэрэглээ болон ашигласан барилгын материал гэсэн 3 чиглэлээр үнэлдэг.</p> <p>Мөн Эрчим хүчний хэмнэлттэй барилгыг үнэлэхийн тулд “Барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам”-ыг Барилга, хот байгуулалтын сайд, Эрчим хүчний сайдын хамтарсан А/257, А/252 дугаар тушаалаар 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдөр батлуулсан. Энэхүү журам батлагдсанаар барилга, орон сууцны эрчим хүчний хэрэглээг зураг төслийн болон ашиглалтын үед тооцооны болон аудитын дүгнэлтээр дүгнэн шинэ барилга, үл хөдлөх хөрөнгөд заавал, ашиглаж буй барилга, байгууламжид сайн дурын гэрчилгээ олгох нөхцөл бүрдсэн.</p> <p>2023 онд:</p> <p>Үндэсний хэмжээнд Ногоон барилгын үнэлгээний системтэй болох, тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай “Ногоон барилгын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх судалгаа” хийх гүйцэтгэгчээр “Монголын Ногоон барилгын хүрээлэн” ТББ-тай 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр 2023/171 тоот гэрээ байгуулсан. Эхний шатны тайлан ирүүлсэн. Ногоон барилгын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх судалгаагаар нэн түрүүн шаардагдах олон улсын ногоон барилгын гэрчилгээжүүлэлтийн түгээмэл хоёр системийг судлан, харьцуулалт хийх замаар “BestGER” гэсэн үнэлгээний системийг нэвтрүүлэх боломжтой талаар санал гаргаад байна.</p> <p>“Ногоон барилгын хүрээлэн” ТББ-аас боловсруулсан “BestGER” Ногоон барилгын үнэлгээний системийн төслийн хэлэлцүүлэгт 2023.12.13-ны өдрийн 09.30-11.00 цагт оролцож, “Барилгын материал”-ын үнэлгээний багт ажиллаж, санал өгсөн. Уг журмын төслийг “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-аас 2023.12.21-ний өдрийн 1/3932 тоот албан бичгээр ирүүлсэн тул “BestGER ногоон барилгын гэрчилгээ олгох журам”-ын төсөлтэй танилцаад санал боловсруулж, 2023.01.05-ны өдрийн 6/36 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн. Барилга байгууламжийн норм нормативын сангийн 2022, 2023 оны төлөвлөгөөнд санхүүжилтыг тусгуулан дараах баримт бичгийг боловсруулахаар техникийн даалгаврыг боловсруулж батлуулан, ажлыг эхлүүлээд байна. Үүнд: “Ногоон барилга байгууламжийг үнэлэх аргачлал” боловсруулах Техникийн даалгавар батлагдсан. “Монголын Ногоон барилгын хүрээлэн” ТББ-тай 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр 2023/90 тоот гэрээ байгуулсан. Эхний болон дунд шатны тайлан ирүүлсэн.</p> <p>“Ногоон барилгыг гэрчилгээжүүлэх журам” боловсруулах Техникийн даалгавар батлагдсан. “Монголын Ногоон барилгын хүрээлэн” ТББ-тай 2023 оны 05 дугаар</p>	100

						сарын 03-ны өдөр 2023/89 тоот гэрээ байгуулсан. Эхний болон Дунд шатны тайлан ирүүлсэн. Барилгын мэдээллийн нэгдсэн системээр журмын төсөлд нээлттэй санал авахаар байршуулсан.	
19	Ногоон гэрчилгээтэй барилга, тоо	-	-			Манай улсад ОУ-ын Санхүүгийн корпорацийн ногоон барилгын анхны EDGE гэрчилгээг "Сакура Проперти" ХХК -ийн гүйцэтгэсэн модон каркас бүхий 70 метр ам дөрвөлжин талбайтай, хоёр давхар амины орон сууцны байшинд олголоо. Уг барилга нь эрчим хүчийг 57 хувь, усны хэрэглээг 27, барилгын материалын 42 хувийн хэмнэлттэй, ахисан түвшний буюу advanced ангиллынх гэрчилгээ юм. MMS Group-ийн бүтээн байгуулсан и нь Дэлхийн хамгийн нэр хүндтэй LEED ногоон барилгын гэрчилгээжүүлэлтийн дээд ангилал "BD+C PLATINUM" болзлыг хангаж Монгол Улс LEED гэрчилгээтэй улсаар албан ёсоор бүртгэгдлээ. Ийнхүү MMS Green Building нь LEED гэрчилгээгээр баталгаажсан МОНГОЛЫН АНХНЫ НОГООН БАРИЛГА болсноор тухайн улсын анхдагч төсөлд олгодог LEED EARTH гэрчилгээг авчээ. Энэхүү төслийн онцлог нь санхүүжилт, архитектур төлөвлөлт, барилга угсралт, инженерийн шийдлүүд нь Монгол залуучуудын гүйцэтгэлээр бий болсон бүтээн байгуулалт юм. Барилгын хувьд Ногоон барилгын голлох шалгуурууд болох сэргээгдэх эрчим хүч, усны хэмнэлт, ногоон байгууламж, дотоод орчны чанарын жишиг шийдэл бүхий бүрэн автоматжуулагдсан ухаалаг барилга юм. MMS Green Building нь Оффис, Засвар үйлчилгээ, Агуулах гэсэн үндсэн 3 блокоос бүрдсэн бөгөөд нийт 10'000м2 талбайн 26%-г байгууламж, 30%-г ногоон байгууламж, 44%-г зам талбай байхаар төлөвлөгдсөн. ОУ-ын Ногоон барилгын гэрчилгээ авсан барилгын тоо – 2 2022-2023 онд МУ-д ногоон барилгын гэрчилгээ авсан барилга байхгүй байна. Олон улсын гэрчилгээ олгох үйл ажиллагаа нь олон үе шаттай байдаг бөгөөд Хаан банк нь өөрсдийн конторын барилга болох "Хаан товер" барилгадаа LEED гэрчилгээ авахаар 2022-2023 онд шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, экспертүүд урьж ажиллуулсан бөгөөд 2024 оны эхний хагас жилд гэрчилгээ олгогдох төлөвтэй байна.	100
20	Шинээр барьж ашиглалтад оруулсан Улаанбаатар хот болон аймгуудын цэвэрлэх байгууламж, тоо	5	8	12	4	Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт хоногт 20000 м3/хоног, БНФУ-ын зээлээр Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл төслийн хүрээнд хоногт 24000 м3/хоног, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт хоногт 3200 м3/хоног, АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр Архангай, Өмнөговь, Дорноговь, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Сүхбаатар аймгийн төв, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Өвөрхангай аймгийн Хужирт сум, Дархан-Уул аймагт 24000 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотод шинэ төв цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 85%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. БНПольш улсын зээлээр Баян-Өлгий, Завхан, Увс, Говь-Сүмбэр аймгуудын төвд барилга угсралтын ажлын гүйцэтгэл 25%-тай цэвэрлэх байгууламж баригдаж байна.	100

21	Орон нутагт шинээр барьсан инженерийн шугам сүлжээний нийт урт, км	100	150	335,6	185,6	Улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгагдсан дараах 13 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж цэвэр усны 20,6км, бохир усны 10,6км, цахилгааны-17,7км, дулааны-11,1км нийт 60км шугам сүлжээг шинээр барьсан. Үүнд: 1.Говь-Алтай аймгийн Халиун сумын ундны усны 4,6 км шугам сүлжээг шинээр барьсан. Гүний худгийн 3 барилгын ажил- 70%; 2.Говь-Алтай аймгийн Цээл сумын цэвэр усны ф50мм-ийн 128,4 м, бохир усны ф150мм-ийн 127,3 м шинээр, гүйцэтгэл-100%; 3.Өвөрхөнгө аймгийн төвд цэвэр усны 385м, бохир усны 352м шугам сүлжээний угсралтын ажил хийгдсэн, 2023 оны төлөвлөсөн гүйцэтгэлээр 100%; 4.Дархан-Уул аймгийн Дархан суманд ус хангамжийн ф160 мм-ээс ф250 мм-ийн 2,25 км шугам сүлжээний ажил хийсэн, 2023 оны төлөвлөсөн гүйцэтгэлээр 100%; 5.Австрийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Дархан-Уул аймгийн төвд 3 байршилд цэвэр усны ф200мм, ф400мм-ийн 500мм-ийн 3,2 км шугам сүлжээний ажил угсралтын ажил, 100%; 6.Хэнтий аймгийн төвд бохир усны ф450мм-ын голчтой 1км шугам сүлжээний ажил гүйцэтгэсэн, гүйцэтгэл 15%; 7.“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл, эхний ээлжийн ИБАХ-50%, ус хангамж-53%, цахилгаан-60%, 2023 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100%; 8.Булган аймгийн Орхон сумын Түүхий эдийн захын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажил, 35%; 9.Дархан-Уул аймгийн Дархан сумын гэрэлтүүлгийн ажил 2023 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн гүйцэтгэл 100%; 10.Дорнод аймгийн Хэрлэн сумын төвд 1800 айлын орон сууцны хорооллын цахилгаан хангамж, инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэл-5%, 2023 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100%; 11.Хэнтий аймгийн төвд бохир усны төв коллекторын шугмын шинэчлэл, өргөж станцын ажлын гүйцэтгэл-20%, 2023 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100%; 12. Сэлэнгэ аймгийн Мандал суманд ариутгах татуургын ф200 мм-ийн голчтой, 6,9 км шугам сүлжээ барьж, 2023.06.23-ны БУ-31/2023 дугаар дүгнэлтээр ашиглалтад оруулсан, 100%; 13.Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд ариутгах татуургын ф250 мм, ф300мм-ийн голчтой, 2,2 км шугам сүлжээг шинээр барьсан. Ажлын гүйцэтгэл 100%.	100
22	Шинээр баригдсан үерийн далан сувгийн урт, км	432,5	465.7	465,7	-	1.УБ хотод 7 төсөл, арга хэмжээний нийт 4,2 км үерийн хамгаалалтын далан, суваг баригдсан үе шатны ажлууд үргэлжилж байна. 2.Орон нутагт 7 төсөл, арга хэмжээний нийт 29 км үерийн хамгаалалтын байгууламж баригдсан.	100
23	Хаягийн мэдээллийн нэгдсэн системийн хөгжүүлэлт, хувь	30	70	90	10	“Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулах” ажлыг “Геомастер” ХХК-гүйцэтгэж, “Топ сүрвэй” ХХК захиалагчийн техникийн хяналтыг хийсэн. эцсийн шатны гүйцэтгэлийг хүлээн авч, санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.	90

						<p>Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн системийг бүрэн нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Барилга, хот байгуулалтын сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 227/A76 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Яам болон зарим албан тушаалтнууд бүтцийн өөрчлөлтөд орсонтой холбогдуулан БХБ-ын сайд ЦХХХ-ны сайдын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 119/A/46 дугаар хамтарсан тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлаж, хийх ажлын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар БХБЯ-ны төрийн нарийн бичгийн дарга томилогдсон бөгөөд БХБЯ, ЦХХХЯ, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн ЗДТГ, Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Харилцаа, холбооны зохицуулах хороо, Үндэсний ДАТА төв, газрын мэргэжлийн байгууллага зэрэг нийт 30 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.</p> <p>Тус Ажлын хэсэг нь нийт 15 удаагийн хурал зохион байгуулсан бөгөөд 2023 онд 18 арга хэмжээг төлөвлөн гүйцэтгэсэн.</p> <p>Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд бүртгэлтэй 964803 хаягийн мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэлтэй 1249248 хаягийн бүртгэлтэй тулгаж шалгах, хот байгуулалтын системд бүртгэлтэй 19308 барилгын мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэлтэй 256975 Ү-дугаартай ҮХЭХ-ийн мэдээлэлтэй тулгаж шалгах, хаягийн мэдээллийн системд бүртгэгдсэн нийслэлийн хэмжээний мэдээлэлд шалгалт хийж засварлах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Мөн нийслэлийн хаягжуулалтад тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, оролцогч байгууллагуудын уялдааг хангах талаар хийсэн ажлыг нийслэл, дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт танилцуулах хурлыг 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Хуралд Барилга, хот байгуулалтын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, нийслэлийн 9 дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга болон Засаг дарга, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын төлөөлүүд, Барилга, хот байгуулалтын сайд болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 227/A76 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн гишүүд нийт 40 хүн оролцож, тулгамдсан асуудлыг хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлж байна. Хаягийн өгөгдлүүдийг улсын хэмжээнд засварлаж, системрүү хөрвүүлэх ажлыг хийсэн.</p>	
24	Ус дамжуулах, түгээх шугамын алдагдлын бууралт, хувь	18,6	10,0	18,2	0,4	Орлого болоогүй усны ихэнх хувь нь дамжуулах, түгээх шугам сүлжээнд алдагддаг.	70
25	Орлого болоогүй усны эзлэх хувийг бууруулах хувь	20,5	17,5	19,5	0,9	2023 онд нийт орлого болоогүй усны эзлэх хувь 19.5% болж, 2020 оны түвшинээс 1,0% буурсан байна.	90

26	Удирдлага, хяналтын ухаалаг систем бүхий инженерийн дэд бүтцэд холбогдсон хот, аймгийн төв, тоо	2	3	4	2	УБ хотын ус хангамжийн системийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах зорилгоор хяналт удирдлагын "СКАДА" системд усны эх үүсвэрүүд, бүх насосны станцууд, усан сан, ус түгээх шугамын хяналтын 70 гаруй байршлыг холбосон.	100
27	Хот, суурин газарт шинээр болон шинэчлэн барьсан нийтийн халуун усны төв, тоо	634	652	656	4	УБ хот, Налайх дүүргийн Чандмань Налайх ОНӨААТҮГ хуучин байсан халуун усны барилгаа шинэчилсэн. Энэ нь 6 шүршүүрийн кабинтай. 2021 онд БХБСайдын багцаас 1,7 тэрбум төгрөгөөр 10 суманд халуун ус барьсан. Улсын хэмжээнд 7 аймгийн 12 суманд нийтийн халуун ус, ахуйн үйлчилгээний барилга барьж байгаагаас 5 байгууламж ашиглалтад орсон 7 барилга он дамжин үргэлжилж байна. Завхан аймгийн Баянхайрхан, Баянтэс сум, Сэлэнгэ аймгийн Шаамар сум, Ховд аймгийн Жаргалант, Үенч сум, Увс аймгийн Зүүнхангай сум, Хөвсгөл аймгийн Баянзүрх, Алаг-Эрдэнэ сум, Хэнтий аймгийн Бор-Өндөр сум, нийт 9 суманд улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийтийн халуун усны барилга угсралтын ажил гүйцэтгэж байна. Эдгээрээс 2023.12-р сарын байдлаар Завхан аймгийн Баянтэс сумын нийтийн халуун усны барилгыг 2023.08.18-ны 21/2023 дугаар Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлтээр, Ховд аймгийн Үенч сумын нийтийн халуун усны барилгыг 2023.06.20-ны ББКД/05/2023 дугаар Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлтээр, Ховд аймгийн Жаргалант сумын нийтийн халуун усны барилгыг 2023.07.27-ны ББКД-84-20/23 дугаар Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын дүгнэлтээр тус тус ашиглалтад оруулж, бусад сумдын нийтийн халуун усны барилгын ажил үргэлжилж байна. - Өмнөговь аймгийн Хүрмэн, Гурвантэс сум, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, нийт 3 суманд ахуй үйлчилгээний төвийн барилга угсралтын ажил гүйцэж байна. 2023.12-р сарын байдлаар Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Нийтийн ахуй үйлчилгээний барилгыг 2023.09.25-нд У-2023/70 дугаар Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр, Гурвантэс сумын Нийтийн ахуйн үйлчилгээний барилгын ажлыг 2023.06.29-ний 3-2023/19 дүгээр Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулсан, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ахуй үйлчилгээний төвийн барилгын ажил үргэлжилж байна.	100
ДҮН							91.48 %

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ